



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1205 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2023 онд хийх ажлын төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг тухай бүр тайлагнаж, ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн (Ө.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Оюунцэцэг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН



Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын
2023 оны 01 дүгээр сарын 16 өдрийн А/08 дугаар

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ 2023 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хугацаа	
				Явцын	Эцсийн
1	2	3	4	5	6
1.1	Дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд шинжилгээ, үнэлгээ хийх.	Хяналт-шинжилгээ, хийсэн бодлогын бичгийн тоо	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бодитой үнэлж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хариуцсан нэгж, албан хаагчдад хүргүүлж, Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	06.12	12.08
1.2	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Хяналт-шинжилгээ, хийсэн хууль тогтоомж, шийдвэрийн тоо	Хэрэгжилтийг бодитой үнэлж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хариуцсан нэгж, албан хаагчдад хүргүүлж, Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	06.21	12.20
1.3	Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр дээд шатны байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийх.	2 удаа	Ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний дагуу хийсэн ажлыг үнэлж, НЗДТГ-т тайлагнахад хяналт тавин ажигласан байна.	06.09	12.08

1	2	3	4	5	6
<p>ЗОРИЛТ 2. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХ, ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:</p>					
2.1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай тохиолдолд зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлж биелэлтийг хангуулах.	Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж, сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байх.	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж, үр дүнг, нөлөөг дээшлүүлсэн байна.	06.14	12.14
2.2	Байгууллагын зохион байгууллагын нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Нэгжийн гүйцэтгэлийн тайланд хагас жилийн тайлагналтад зөвлөмж өгсөн байх.	Зөвлөмж өгч үйл ажиллагааны үр дүнгийн тайлагналтыг сайжруулсан байна.	Жилд нэг удаа	
2.3	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаарын биелэлтэд үнэлгээ өгөх.	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын тоо	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн хэрэгжилтэд үнэлгээ өгсөн байна.	Тухай бүр	
2.4	Газрын Удирдлагын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд үнэлгээ өгөх.	Удирдлагын зөвлөлийн хурал дээр газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын тоо	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелэлтэд үнэлгээ өгсөн байна.	Тухай бүр	
2.5	Засгийн газрын гишүүн болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд үнэлгээ өгөх.	Гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнг бодитой үнэлсэн байх.	Гэрээний хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж тайлагнасан байдлад хяналт тавьж, үнэлгээ өгсөн байна.	06.12	12.11
2.6	Шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тоо	Дэд шатны байгууллагад тайлагнахад ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлсэн байна.	Тухай бүрт	

1	2	3	4	5	6	
ЗОРИЛТ 3.БУСАД ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:						
3.1	Өргөдөл шийдвэрлэлтийн хяналт-шинжилгээ, хийж, тохиолдолд зөвлөмж гаргах.	гомдлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байх.	Хагас, бүтэн жилээр тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байх.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой зөвлөмж өгч, тайлангийн үр нөлөө, шийдвэрлэлт сайжирсан байна.	06.29	12.28
3.2	Албан бичиг шийдвэрлэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах.	Хагас, бүтэн жилээр тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байх.	Албан бичиг шийдвэрлэлтийн тайланд зөвлөмж өгч, тайлангийн үр нөлөө, шийдвэрлэлт дээшилсэн байна.		06.29	12.28
3.3	Бусад үйл ажиллагааны чиглэлээр шаардлагатай тохиолдолд шинжилгээ, үнэлгээ хийх.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тоо	Үнэлгээг хийж, удирдлагад танилцуулсан байна.			Тухай бүр